

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 3 гишүүн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд баталгаа, батлан даалтыг аливаа этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө гаргах эрхтэй боловч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээний үүргийн гүйцэтгэлд зөвхөн банкны баталгааг хүлээн зөвшөөрч байгаа нь даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн зах зээлд даатгагчийн баталгаа гаргах боломжийг хязгаарласан сөрөг үр дагавар үүсэж байгааг өөрчлөхөөр хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан даатгалын баталгааны санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал даатгал эрхлэгч байгууллагууд өөрийн хөрөнгийн хэдэн хувьд даатгалын баталгаа гаргах боломжтой эсэх, мөн даатгалын компанийг эрсдэлээс хамгаалахын тулд холбогдох байгууллагуудын мэдээллийн эх сурвалж, мэдээлэл харилцан солилцох боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин төрийн болон орон нутгийн тендерт оролцогч компаниудад даатгалын сонголт бий болж байгаа нь сайшаалтай боловч томоохон хэмжээний тендерийн эрсдэлийг даатгалын компани дангаар авч явах чадвар хараахан бүрдээгүй байгааг анхаарах, мөн даатгалын компаниуд шимтгэл хөөж томоохон тендерт оролцож даатгалын төлбөр төлөх тохиолдолд гэрээний дагуу нөхөн төлбөрийг төлж чадахгүй нөхцөлд хүрэх вий гэсэн болгоомжлол байгаа учраас тодорхой хэмжээний хязгаар тогтоох нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал даатгалын хуулийн төсөлд даатгалын байгууллагуудын баталгааны эх үүсвэрийг тодорхой болгож цаашид томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд эрсдэл үүссэн тохиолдолд авах хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, мөн банк, даатгалын байгууллагуудын мэдээллийн системийг боловсронгуй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН